

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“МСМ ГРУПП” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН
ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
“ЭКОЛОГИЙН БҮТЭЭМЖ” ХХК

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ
НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БҮЙ “ХИМИЙН БОДИСЫН
АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

БАТАЛСАН:
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛ ОРЧНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:

“ЭКОЛОГИЙН БҮТЭЭМЖ” ХХК-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Ч.СУВД

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ	4
1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	4
1.1 ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	4
1.2 ТӨСЛИЙН БАЙРШИЛ	4
1.3 ХИМИЙН БОДИСЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	5
1.4 ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ	5
1.5 ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ	6
БҮЛЭГ 2. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	7

2.1. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	7
2.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
2.3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
2.4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
2.5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
2.6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
2.7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	16
2.8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ	21
ДҮГНЭЛТ	22

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. БОМТөлөвлөгөөний зардлын биелэлт	7
Хүснэгт 2. БОМТөлөвлөгөөний зардлын задаргааны биелэлт	7
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал /мян. төг/	9
Хүснэгт 4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн биелэлт	12
Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
Хүснэгт 6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	15
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	19
Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	20
Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Химийн бодисын агуулахын байршил	5
Зураг 2. Химийн бодисын агуулах	6

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3.4-т “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасны дагуу төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батална” гэж заасны дагуу тус 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаал, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу тус тус үндэслэн боловсруулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, нийгмийн асуудал, байгаль орчин, тухайн хороонд ажиллаж амьдрах иргэдийн харилцаа хариуцсан нэгж хэсгүүдийн хамтын ажиллагааг хангасан удирдлага зохион байгуулалтын механизмыг хэрхэн бүрэлдүүлж, зардлын төлөвлөгөөг тайлагнахад ашиглагдах баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбай, түүний орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Энэхүү биелэлтийн тайланг дүгнүүлэх, хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

1. Ажиллагсад байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхыг зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, ур чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.
2. Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцож, байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж хамгаална.
3. Төсөл хэрэгжиж буй хороо дүүргийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана.
4. Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн төслийн БОМТ-тэй танилцан баталж, төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох ба жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж, дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. БОМТ-ний хэрэгжилтэд тухайн Нийслэлийн

**“МСМ ГРУПП” ХХК-ийн хан-уул дүүргийн 3-р хороонд хэрэгжүүлж буй “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ”
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, Засаг дарга, БОУАӨЯ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй ба тэдгээрт холбогдох мэдээлэл ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг болно.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төсөл хэрэгжүүлэгч:

бүртгэлийн дугаар:

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

“МСМ Групп” ХХК Улсын

9019009002

МСМ Групп ХХК-ийн байр, Чингисийн өргөн чөлөө- 62, Үйлдвэрийн баруун бүс -17070, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Улаанбаатар — 211213, Монгол улс, Т/шуудан хайрцаг — 154 (+976) 70181111

Утас:

И-мэйл:

information@msmco.net

www.msmgroup.mn


МСМ Групп ХХК нь анх 1998 онд байгуулагдсан бөгөөд компанийн хувьцааг Лауренц Мелшерс, Дэвид Райнер, Монголиа Экуйпмент Сервисес компани нар эзэмшдэг. МСМ Групп ХХК нь дараах 4 салбарт үйл ажиллагаа явуулдаг.

1. Барилга, уул уурхайн тоног төхөөрөмжийн салбар
2. Автомотивын салбар
3. Хөдөө аж ахуйн салбар
4. Шингэн хүнсний салбар

1.2 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд урд талаараа төв зам ба Туул гол, хойд талаараа 3-р цахилгаан станцтай хил залган оршдог. “МСМ Групп” ХХК нь 2019 онд өөрийн үйлдвэрийн баруун бүс 17-070-60 тоотод, 2282 м² талбай бүхий химийн бодис хадгалах зориулалттай 2 агуулахын байрыг тус тус ашиглалтад оруулан, мэргэжлийн хяналтын, хяналт шалгалтаар дүгнэлт гаргуулан химийн бодис хадгалах зориулалт стандартын дагуу тохижуулан үйл ажиллагаа явуулж байна. Тус компанийн үйл ажиллагаа буй газар нь “МСМ Групп” ХХК-ийн охин компани болох “Бетастар” ХХК-ийн эзэмшилд байдаг бөгөөд Аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ /№ 000324191 тоот/-г Хан- Уул дүүргийн Засаг даргын 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/590 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын 1780905043/18639308732077 дугаар бүхий 40040 м² талбайг 15 жилийн хугацаатай 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр авсан байна. “МСМ Групп” ХХК нь 2019 онд БНХАУ, ОХУ, Тайвань, Малайз, Индонез, Австрали, Сингапур улсад үйлдвэрлэсэн 15 төрлийн химийн нэгдэл агуулсан 971 кг химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг импортлон худалдаалахаар захиалга авсан байна. Химийн бодисын агуулахын байр нь химийн бодис хадгалахад тавигдах шаардлагын дагуу тусгай агуулахын өрөө гарган бэлтгэсэн бөгөөд агуулах нь 1 давхар, зоорьгүй, газардуулга, аянга зайлуулагчтай, бетон шалтай байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй, агаар сэлгэх механик салхивчтай, цонх нь төмөр тортой, дулаан, бохир ус нь төвийн системд холбогдсон, гадна талын хашаа нь блокон ханатай, 24 цагийн харуул хамгаалалттай, хүн ам бага суурьшсан хороолол, усан сан бүхий газар, үер, усны аманд байрлаагүй хийгдсэн болно.

“МСМ ГРУПП” ХХК-ийн хан-уул дүүргийн 3-р хороонд хэрэгжүүлж буй “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 1. Химийн бодисын агуулахын байршил

1.3 ХИМИЙН БОДИСЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“МСМ Групп” ХХК нь БНХАУ, ОХУ, Тайвань, Малайз, Индонез, Австрали, Сингапур улсад үйлдвэрлэсэн 179 төрлийн химийн нэгдлийг Замын үүд, Алтанбулаг, Буянт ухаа, Гашуун сухайтын боомтоор импортлон химийн бодисын агуулахад ангилан хадгалж, гэрээний дагуу худалдаалдаг.

- Германы BASF /BASF/ болон Австралийн BTC /MTS/ компанийн Монгол улс дахь албан ёсны төлөөлөгч
- Барилгын материал үйлдвэрлэх, ашигт малтмал боловсруулах зориулалттай химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, нийлүүлэлт, хэрэглээний хяналт
- Эрдэс баяжуулалтын бүтээгдэхүүн
- Хандлан баяжуулалтын бүтээгдэхүүн
- Усны чанар сайжруулах химийн бүтээгдэхүүн
- Хатуу шингэнийг салгах бүтээгдэхүүн

1.4 ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ

Химийн бодисын агуулахад химийн бодис хадгалахад тавигдах шаардлагын дагуу 1 давхар газардуулга, аянга зайлуулагчтай, бетон шалтай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй, агаар сэлгэх механик сапхивчтай, дулаан, бохирын систем нь төвийн системд холбогдсон 24 цагийн харуул хамгаалалттай, хотын хүн ам бага суурьшсан бүсэд, усан сан бүхий газар, үер усны аманд байрлаагүй хийгдсэн байна.

Тусгуулах нь ан цав хотгор гүдгэргүй цементэн шалтай, ус тогтохгүй зэвэрдэггүй будгаар будсан налуу дээвэртэй, агуулахын хана нь химийн бодисоос үүссэн тоос, уур манан тогтохооргүй гөлгөр гадаргуутай, гадна талдаа хаалга болон орчныг тусгасан гэрэлтүүлэгтэй, аваарын 10 гарцтай, барилга байгууламж нь мэргэжлийн байгууллагын хийсэн газардуулгын системтэй.

“МСМ ГРУПП” ХХК-ийн хан-уул дүүргийн 3-р хороонд хэрэгжүүлж буй “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

1.5 ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

“МСМ групп” ХХК нь уул уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, усны шугам хоолойд өнгөр үсэхээс сэргийлдэг, хатуу шингэнийг ялгах зэрэг үйл ажиллагаанд хэрэглэдэг, нийт 179 нэр төрлийн химийн хортой болон аюултай бодисыг тус 2 агуулахад (Зураг №2) хадгалан худалдаалдаг. Химийн бодисын агуулах нь нийт 2282 м² талбайтай, 12000 тн химийн бодис нэг дор хадгалах багтаамжтай ба хадгалж буй химийн бодисыг худалдаалж сэлгэх хүчин чадлаар тооцвол жилд 150000 тн бодис хадгалах хүчин чадалтай.



Зураг 2. Химийн бодисын агуулах

БҮЛЭГ 2. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“МСМ ГРУПП” ХХК-ий Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй “Химийн бодисын агуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОНХАЖ Сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны А-117 дугаар тушаал, 2019 оны А/6-18 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын шаардлагад нийцүүлж боловсруулсан ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг мөн дээрх хууль журамд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулав.

Хүснэгт 1. БОМТөлөвлөгөөний зардлын биелэлт			
№	Ажлын нэр	Тухайн жилийн БОМТ-ний Зардал (мян.төг)	Биелэлтийн зардал (мян.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	28 000.0	30 090.980
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	5 600.0	5 000.000
3	Нийт зардал	33 600.0	35 090.980


Хүснэгт 2. БОМТөлөвлөгөөний зардлын задаргааны биелэлт			
№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Тухайн жилийн БОМТ-ний Зардал (мян.төг)	Биелэлтийн зардал (мян.төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,500,000	3,500,000
2	Орчны тохиржилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	3,000,000	2 688,000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3,500,000	3,500,000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18,000,000	20 402.980
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	5,000,000	5,000,000
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	100,000	-
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	500,000	-
Нийт зардал		33 600,0	35.090.980

2.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Төсөл хэрэгжүүлэгч нь 2024 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Химийн бодисын агуулахад цахилгаан үзлэг хийсэн. Хавсралт №1.

Химийн бодисын агуулахын цахилгаан үзлэг



Ерөнхий оруулгын самбар-1



Ерөнхий оруулгын самбар-2



Гэрэлтүүлэг



Розетка

2. Мэргэжлийн байгууллага, мэргэжилтний оролцоотойгоор химийн бодистой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан.

Аюулгүй ажиллагааны сургалт



2.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал /мян.төг/

№	Сөрөг нөлөөлөл					Урьдчилан сэргийлэх, бууруулах, аригтах арга хэмжээ	Арга хэмжээний цаг хурца	Нэгжийн өртөг	БОМТ-ний зардал	БОМТ-ний биелэлтийн зардал
2	Агуулахын орчны тоосжилт болон химийн бодисын хадгалалт, ууршилтаас ялгарах хий нь агаар дахь тоосжилт ба чанарын найрлагыг тодорхой хэмжээгээр өөрчлөх боломжтой.					Агуулах болон ажлын байранд шинжилгээ хийлгэж, бохирдлыг хянаж байх /жилд 1 удаа шинжилгээ хийх/	Төсөл хэрэгжих бүхий л үед	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу	Агаарын чанарын сорьц аван итгэмжлэгдсэн лаборатори "Ногоон титэм" ХХК-иар Жижиг ширхэглэлт тоосонцор (PM 2.5), Азотын давхар исэл, Хүхэрлэг хийн сорьцыг шинжлүүлсэн.	
	ХӨРСӨН БҮРХСВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ									
3	Ахуйн хатуу хог хаягдлыг тодорхой зохицуулалтгүй хаях нь хөрсний бохирдлын гол эх үүсвэр болох					Ахуйн хатуу хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, тогтмол хугацаанд зайлуулах	Төсөл хэрэгжих бүхий л үед	Тэрээний дагуу	Хан-Уул дүүргийн Эко хотын тээвэр ААТҮТ-аар тогтмол тээвэрлүүлдэг.	Хөрсний шинжилгээг Инженер геодези, Хангай ХХК-иас шинжлүүлсэн.
4						Агуулахын орчны хөрсний шинжилгээг хийлгэх		Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу	Хөрсний шинжилгээг Инженер геодези, Хангай ХХК-иас шинжлүүлсэн.	
УРГАМЛЫН НӨМӨР										
5	Тээвэрлэх болон агуулахад татан авчрах, хадгалалтын горим зарчидсөнөөр химийн бодис хөрсөнд навчиж, ургамалжигтанд нөлөөлөл үзүүлэх, бохирдуулах					Химийн бодис тээвэрлэх,хадгалах журамд заагдсаны дагуу алдаж асрахас сэргийлэх арга хэмжээ авах	Төсөл хэрэгжих бүхий л үед	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу	Хөрсний мониторингийн цагаас дээжлэлт хийн шинжлүүлсэн.	
АМЬТНЫ АЙМАГ										
6	Бодисыг гадаргууд алдсан тохиолдолд их хэмжээний бодисоор бохирдсон ургамлыг мал, амьтан идсэнээр хордох					Төслийн үйл ажиллагаа, осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд навчиж, ургамалжигтанд нөлөөлөл үзүүлэх,	Төсөл хэрэгжих бүхий л үед	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу	Хөрсний мониторингийн цагаас дээжлэлт хийн шинжлүүлсэн.	

		Бохирдүүлхаас урьдчилан саргилгах арга хэмжээ байнга авч байх шаардлагатай	-		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ҮҮСЭЖ БОЛЗОШГИ ОСОЛ, ЭРСДЭЛИЙГ БУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ					
7	Галын болзошгүй аюулаас үүдэн гал гарах эрсдэл	Агуулахын гал унтраах анхан баттгал багаж хэрэгслийн /гал унтраагуур, элс, хүрч г.м/ байдалд хяналт тавих монтажийн бүрэн бүтэн Агуулахын цахилгаан	Жилд 1 удаа ажигчдыг эрүүл мэндийн үзлэгэд хамруулах	Химийн бодисын агуулахын ажигчдад нэг бүрийн хамгаалах хэрэгслээр байнга хангах	Үйл ажиллагааны зардалд
8	Галын болзошгүй аюулаас үүдэн гал гарах эрсдэл	Агуулахын гал унтраах анхан баттгал багаж хэрэгслийн /гал унтраагуур, элс, хүрч г.м/ байдалд хяналт тавих монтажийн бүрэн бүтэн Агуулахын цахилгаан	Жилд 1 удаа ажигчдыг эрүүл мэндийн үзлэгэд хамруулах	Химийн бодисын агуулахын ажигчдад нэг бүрийн хамгаалах хэрэгслээр байнга хангах	Үйл ажиллагааны зардалд
9	Химийн бодистой харьцаж буй ажигчтнууд хувийн агуулах цэвэр, эрүүл ахуйн дүрмийг мөрдөж ажиглаагүйгээс эрүүл мэндэд сөрөөр нөлөөлөх	Ажигчдын эрүүл мэндийн үзлэг	Жилд 1 удаа ажигчдыг эрүүл мэндийн үзлэгэд хамруулах	Химийн бодисын агуулахын ажигчдад нэг бүрийн хамгаалах хэрэгслээр байнга хангах	Үйл ажиллагааны зардалд
10	Химийн бодистой харьцаж буй ажигчтнууд хувийн агуулах цэвэр, эрүүл ахуйн дүрмийг мөрдөж ажиглаагүйгээс эрүүл мэндэд сөрөөр нөлөөлөх	Химийн бодистой харьцаж, ажигчдын үеийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /гүл, резинэн химийн бээлий, хамгаалагчтын хошуувч г.м/ байдалд хяналт тавих монтажийн бүрэн бүтэн Агуулахын цахилгаан	Жилд 1 удаа ажигчдыг эрүүл мэндийн үзлэгэд хамруулах	Химийн бодисын агуулахын ажигчдад нэг бүрийн хамгаалах хэрэгслээр байнга хангах	Үйл ажиллагааны зардалд
11	Химийн бодистой харьцаж буй ажигчтнууд хувийн агуулах цэвэр, эрүүл ахуйн дүрмийг мөрдөж ажиглаагүйгээс эрүүл мэндэд сөрөөр нөлөөлөх	Химийн бодистой харьцаж, ажигчдын үеийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /гүл, резинэн химийн бээлий, хамгаалагчтын хошуувч г.м/ байдалд хяналт тавих монтажийн бүрэн бүтэн Агуулахын цахилгаан	Жилд 1 удаа ажигчдыг эрүүл мэндийн үзлэгэд хамруулах	Химийн бодисын агуулахын ажигчдад нэг бүрийн хамгаалах хэрэгслээр байнга хангах	Үйл ажиллагааны зардалд
12	Химийн бодистой харьцаж буй ажигчтнууд хувийн агуулах цэвэр, эрүүл ахуйн дүрмийг мөрдөж ажиглаагүйгээс эрүүл мэндэд сөрөөр нөлөөлөх	Химийн бодистой харьцаж, ажигчдын үеийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /гүл, резинэн химийн бээлий, хамгаалагчтын хошуувч г.м/ байдалд хяналт тавих монтажийн бүрэн бүтэн Агуулахын цахилгаан	Жилд 1 удаа ажигчдыг эрүүл мэндийн үзлэгэд хамруулах	Химийн бодисын агуулахын ажигчдад нэг бүрийн хамгаалах хэрэгслээр байнга хангах	Үйл ажиллагааны зардалд
2024 оны Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал		3,500,000.00 төгрөг			

“МСМ ГРУПП” ХХК-ийн ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2.3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58-р зарлиг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн талбай нь бетон хучилттай, мод тарих талбайн хүрэлцээ хангалтгүй учир төсөл хэрэгжүүлэгч нь Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын Газарт 2024.07.31 өдрийн 1400 тоот албан тоот хүргүүлсэн. Засаг дарга мод тарих талбай зааж өгсний дагуу 120 мянгатын автобусны буудалд шинэс, хайлаас тарьсан. МСМ Групп ХХК-ний Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт илгээсэн Мод тарих талбай авах тухай албан тоот, “Хотон цэцэг” ХХК-ний үнийн саналыг Хавсралт №2-т оруулав.



Хүснэгт 4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн биелэлт

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	БОМТ-ний зардал	БОМТ-ний биелэлтийн зардал
1	Төслийн талбайд мод, бут суулгах	Шинэс хайлаас тарьж ургуулах	120 мянгалын автобусны буудал	ш	10 шинэс хайлаас 11 хайлаас	Шинэс 80.000 Хайлаас 4.000	3.000.000	2,688,000 Шинэс, хайлаас, модны дуусал, үндэс бэхжүүлэгч, энс, үртэс, бууц, хар шороо, модны витамин зэрэг мод тарихад шаардлагатай материалыг “Хотон цэцэг” ХХК-иас худалдан авч ХҮД-ын Засаг даргын заасан талбайд мод тарьсан.
НИЙТ ЗАРДАЛ								2,688,000.00 төгрөг

2.4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон ут асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай. “МСМ групп” ХХК-ийн төслийн байршил, онцлогоос хамаараад түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний ажил хийгдэхгүй болно.

2.5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Осол эрсдэлийн тухай Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн Бүлэг 4. Эрсдэлийн үнэлгээ, менежмент, ХАБЭА-д тодорхойлон тусгаж өгсөн. Агуулахын Ажилчид нь химийн бодистой харьцах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, арга барилыг бүрэн эзэмшсэн байхаас гадна, болзошгүй ослоос сэргийлж, анхаарал болгоомжтой ажиллах нь чухал юм. Осол эрсдэл өндөр байгаатай холбогдуулж ажилчдыг осол эрсдэлээс хамгаалах арга хэмжээг 2024 онд төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилсан зардлыг төлөвлөвөө.

Химийн бодисын хадгалалт, аюулгүй байдал, Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан байна.



“МСМ ГРУПП” ХХК-ИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮИ “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 5. Осол, эрсдэлтийн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал /мян.төг/

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Үрдчилэн сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний зар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төгр	БОМТ-ний нийт зардал (мян.төг)	2024 оны БОМТ-ний биелэлт
1	Химийн бодис тээвэрлэх болон худалдаалах явцад сав баглаа боодол зарарч, асгарч болзошгүй.	Химийн бодисыг зөөж, тээвэрлэхэд зориулалтын тэрэг ашиглах	Химийн бодис худалдаалах явцад	-	-	-	Химийн бодисыг зөөж, тээвэрлэхэд зориулалтын тээврийн тэрэг ашигладаг.
2	Химийн бодисын хадгалалтын горим зөрчилдсөнөөс буюу хоорондоо урвалд орсноор тэсрч, гал тиймэр гарч болзошгүй	Химийн бодисын хадгалалт, аюулгүй сургалт зохион байгуулж байх	Ажилчдад	-	2.000.000	2.000.000	Мэргэжлийн байгууллалатай хамтран Химийн бодисын хадгалалт, аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулсан.
3	Болзошгүй осол, саатаг, техник төхнөлгийн шугам сулжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Галын аюулаас үрдчилэн сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Ажилчдад	-	1.500.000	1.500.000	Мэргэжлийн байгууллалатай хамтран Галын аюулаас үрдчилэн сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан.
НИЙТ ЗАРДАЛ		3.500.000 төгрөг					

“МСМ ГРУПП” ХХК-ийн хан-уул дүүргийн 3-р хороонд хэрэгжүүлж буй “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2.6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хатуу хог хаягдлыг Эко хотын тээвэр ААТҮГ, ХУД-ийн 3-р хорооны Засаг даргатай 2024 оны 01 сарын 12-ны өдөр хийсэн Хог хаягдал, цуглуулах, тээвэрлэх гэрээний дагуу хог хаягдлыг тээвэрлүүлж байна. Хавсралт №3.

Аюултай хог хаягдлыг Түмэн эгшиг ХХК-тай 2024 оны 09-р сарын 27-ны өдрийн №А/24/054 тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээний дагуу аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж байна. Хавсралт №4.

Хүснэгт 6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй № аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэмжих нэгж	БОМТ-ний нийт зардал	БОМТ-ний биелэлт
1	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх	Хатуу хог хаягдлыг ХУД-ийн Эко хотын тээвэр ААТҮГ-тай гэрээ байгуулан тогтмол тээвэрлүүлсэн	тонн	Гэрээний дагуу	1.800.000
2	Аюултай хог хаягдал шилжүүлэх	Түмэн эгшиг ХХК- тай байгуулсан гэрээний дагуу	кг, тонн	Гэрээний дагуу	18.602.980
НИЙТ ЗАРДАЛ				20,402,980.00 төгрөг	

2.7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Агаарын хэмжилт судалгаа:

PM2.5 Нарийн ширхэглэлт тоосонцор:

Агаарын чанарыг мониторингийн 3 цэгээс 2024.04.17 өдөр PM2.5-ийг Итгэмжлэгдсэн лаборатори “Ногоон титэм” ХХК-д шинжлүүлсэн.

Агаарын чанарын шинжилгээний үр дүн:

PM 2.5 тоосонцрын шинжилгээний сорьц цуглуулсан байршил:

- Химийн бодисын агуулах: 0.29 мг/м³
- Үйлдвэрийн агуулахын гадаа ачаа буулгах тавцан: 0.28
- Бетон нэмэлтийн үйлдвэр: 0.11

Азотын давхар исэл, Хүхэрлэг хийн агууламж:

Төслийн талбайд хийсэн нийт тоосонцрын хэмжилтийн агууламж нь Монгол улсын стандарт MNS 4585:2016 стандартад нийцсэн үзүүлэлттэй байна. (Хавсралт №5)

Агаарын чанарын мониторингийн 3 цэгээс Хүхэрлэг хий (SO2), Азотын давхар исэл (NO2)-ийг Итгэмжлэгдсэн лаборатори Ногоон титэм ХХК-д инжлүүлсэн.

Байршил	NO2	SO2
Химийн бодисын агуулах	86.34 мкг/м³	143.39 мкг/м³
Үйлдвэрийн агуулахын гадаа ачаа буулгах тавцан	46.63 мкг/м³	78.85 мкг/м³
Бетон нэмэлтийн үйлдвэр	32.95 мкг/м³	191.22 мкг/м³
MNS 4585:2016	200.0мкг/м³	450.0мкг/м³

Төслийн талбайд хийсэн Азотын давхар исэл, Хүхэрлэг хийн хэмжилтийн агууламж нь Монгол улсын стандарт MNS 4585:2016 стандартад нийцсэн үзүүлэлттэй байна. (Хавсралт № 6)

Агаарын чанарын мониторингийн судалгаа





Усны хэмжилт судалгаа:

Усны дээжлэлт хийн 2024.05.15 өдөр итгэмжлэгдсэн лаборатори “Ханлаб” ХХК-д шинжлүүлсэн. Лабораторийн дүнгээс харахад Монгол улсад мөрдөгдөж буй “Ундны усны MNS 0900:2018 стандарт”-ын шаардлага хангаж байна. (Хавсралт №9)

Усан орчны мониторингийн судалгаа



Хөрсний хэмжилт судалгаа:

Хөрсний дээжлэлт хийн 2024.09.02 өдөр итгэмжлэгдсэн лаборатори “Ханлаб” ХХК-д шинжлүүлсэн. Химийн бодисын агуулах, Бетон нэмэлтийн үйлдвэр орчмоос авсан дээжийн хариу нь MNS 5850:2019 стандартад нийцэж байна. (Хавсралт №8)

2024 оны 08-р сарын 27 өдөр Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори “Инженер геодези” ХХК-д Хуучин хогийн цэг, Химийн бодисын ачаа буулгах тавцангийн хажуу талаас Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох зорилгоор дээжлэлт хийсэн нь MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020 стандартад нийцэж байна. (Хавсралт № 8)

Хөрсөн бүрхэвчийн мониторингийн судалгаа



“МСМ ГРУПП” ХХК-ийн Хан-уул дүүргийн 3-р хороонд хэрэгжүүлж буй “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Шинжилгээ хийсэн огноо	Нэгжийн зардал, төг	БОМТ-ийн зардал, төг	БОМТ-ийн биелэлтийн зардал
ХӨРСӨН БҮРХЭВЧ						
1	Хөрсний эрүүл ахуй	Ачаа буулгах тавцан	2024.04.17 2024.08.27 2024.09.02 2024.09.03	800.000	800.000	2.250.000 Хөрсөн бүрхэвчийн дээжлэлт хийн итгэмжлэгдсэн лаборатори "Ханлаб" ХХК, "Инженер геодези"-нар шинжлүүлсэн.
2	Хөрсний хими, физик			800.000	800.000	
3	Хөрсний хүнд металл			650.000	650.000	
УСАН ОРЧИН						
4	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн	Ажилчдын ундны уснаас	2024.05.15	250.000	250.000	750.000.000 Уснаас дээжлэлт хийн итгэмжлэгдсэн лаборатори "Ханлаб" ХХК-нар шинжлүүлсэн.
5	Ундны усны бүрэн шинжилгээ			250.000	250.000	
6	Ундны усан дахь хүнд металлын агууламж			250.000	250.000	
АГААР						
7	Орчны агаарын чанарын шинжилгээ	Үйлдвэрийн/агуулахын гадна, дотор агаар	2024.04.17 2024.09.03	2.000.000	2.000.000	2.000.000 Агаарын чанарын дээжлэлт хийн Эрүүл ахуй, хор судлалын лаборатори "Ногоон титэм" ХХК-нар шинжлүүлсэн.
НИЙТ ЗАРДАЛ			5.000.000 төгрөг			

“МСМ ГРУПП” ХХК-ийн ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮИ “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЗЛТИЙН ТАЙЛАН

2.8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үдирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ				НИЙТ ЗАРДАЛ		
	Үрдчилэн тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар	1	2	
1	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах	Дотоод төлөвлөгөөгөөр	2024	“МСМ групп” ХХК	-		
2	Тухайн жилийн байгаль орчны менежментийн биелэлтийн тайланг боловсруулж дүгнүүлэх	Дотоод төлөвлөгөөгөөр	2024	“МСМ групп” ХХК	-		
					100,000. төгрөг		

2.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛЛИЙН БҮСД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

№	БОМТ, БОМТ-ний оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохин байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцсан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохин байгуулах газар	НИЙТ ЗАРДАЛ			500,000 төгрөг				
								1	Нийслэлийн Байгаль орчны газар, "МСМ групп" ХХК	Тайлан	Биелэлт тайлан	2024 оны 11-р сарын 1-ний дотор	500,000.00	Байгаль орчны газрын мэргэжилтэн, компанийн удирдлагууд	Улаанбаатар хот

2.8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЗЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2024 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3.500.000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	2.688.000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3.500.000
4	Хор хаягдлын менежментийн төлөвлөгөө	20.402.980
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	5.000.000
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	-
НИЙТ ЗАРДАЛ		35.090.980

Хавсралт №1. Цахилгаан үзлэгийн тайлан



ЦАХИЛГААН ҮЗЛЭГИЙН ТАЙЛАН



/Сүхэ Монголиа ХХК - Химийн үйлдвэр/

Улаанбаатар




2024

**Химийн үйлдвэрийн цахилгаан үзлэгийн
тайлан /фото/**


Төслийн нэр / Project name	Сүхэ Монголи ХХК- Химийн үйлдвэр
Ерөнхий гүйцэтгэгчийн нэр / Company name	"Монхорус Электрикс" ХХК
Их ба дэд ажлын актын нэр /	Цахилгаан үзлэг

	Ажлын нэр:	Ерөнхий оруулсан самбар-1	
	Байршил:	Химийн үйлдвэр	
	Тайлбар:	Цэгцлэгээ хийх Төгсгөөр ашиглах Дижитал метр ажиллахгүй	
	Ажлын нэр:	АВР самбар	
	Байршил:	Химийн үйлдвэр	
	Тайлбар:	Гаргалгаа EOC-1 руу холбогдсон	
		Ажлын нэр:	ХС-5
		Байршил:	Химийн үйлдвэр
		Тайлбар:	Оруулсан холбоот сайжруулах Цэгцлэгээ хийх Төгсгөөр ашиглах

Төслийн нэр / Project name	Сүхэ Монголын ХХК- Хиймийн үйлдвэр
Ерөнхий туйлгэгчийн нэр / Company name	"Монхорус Электрикс" ХХК
На бие дэлд ажлын актын нэр /	Цахилгаан үйлэг


			
Ажлын нэр:	ХС-3	Ажлын нэр:	ХС-4
Байршил:	Хиймийн үйлдвэр	Байршил:	Хиймийн үйлдвэр
Тайлбар:	Цэвэрлэгээ хийх	Тайлбар:	
			
Ажлын нэр:	ХС-2	Ажлын нэр:	Зөөврийн моторын самбар
Байршил:	Хиймийн үйлдвэр	Байршил:	Хиймийн үйлдвэр
Тайлбар:	Цэвэрлэгээ болон цэвэрлэгээ хийх	Тайлбар:	Автоматыг чадлаас хамааруулан сонгох Кабель солих

Төслийн нэр / Project name	Сика Монголын ХХК- Химийн үйлдвэр
Ерөнхий гүйцэтгэгчийн нэр / Company name	"Монхорус Электрив" ХХК
Ил бг дэлг ажлын актын нэр /	Цахилгаан үйлдэг

			
Ажлын нэр:	Гэрэлтүүлэг	Ажлын нэр:	Гэрэлтүүлэг
Байршил:	Химийн үйлдвэр	Байршил:	Химийн үйлдвэр
Тайлбар:	Залын 11ш гэрэл солих	Тайлбар:	ОГ-ийг сөнөөхийг тусгажээ авахгүй байх
			
Ажлын нэр:	Розетка	Ажлын нэр:	3-р давхрын самбар
Байршил:	Химийн үйлдвэр-Оффис-3F	Байршил:	Химийн үйлдвэр-Оффис
Тайлбар:	Уртасгагч ашиглахгүй байхад ирээдүй розетка суулгах	Тайлбар:	Гэрэлтүүлэг болон розеткууд хэвийн

Төслийн нэр / Project name	Сүхэ Монголын ХХК- Хичийн үйлдвэр
Ерөнхий гүйцэтгэгчийн нэр / Company name	"Монхорус Электрикс" ХХК
На бг дэд ажлын актын нэр /	Цахилгаан үзэг

 693204 4-15-004 Хичийн үйлдвэр-Оффис	Ажлын нэр:	Лабораторийн өрөөний гэрэлтүүлэг
	Байршил:	Хичийн үйлдвэр-Оффис
	Тайлбар:	Гэрлийн ламп солих /хос/

 693204 4-15-004 Хичийн үйлдвэр-Оффис	Ажлын нэр:	Лабораторийн өрөөний самбаруудын үзэг
	Байршил:	Хичийн үйлдвэр-Оффис
	Тайлбар:	Цэнгэлээ хийх

Химийн үйлдвэрт хийсэн анхан шатны үзлэгийн тайлан

	Цахилгаан угсралт хийсэн огноо:	2024.10.12
1	Байршил:	Сика Монголна ХХК үйлдвэрийн байр
2	Үзлэгээр шалгасан:	Ерөнхий оролтын самбар, тохөөрөмжийн самбар, гэрэлтүүлгийн самбарууд
3	Дүгнэлт:	Дэд өртөөний шугам 3.4-оос АВВГ /3х185mm ² +1х95mm ² / кабелиар ЕС.3-т холбогдож, ЕС.3-аас химийн үйлдвэрийн ЕОС-1, ЕОС-2 самбар холбогдсон. Ерөнхий оролтын самбарын дижитал метрууд ажиллагаагүй болсон. Самбарын холболтууд дээр зориулалтын тэгсгөвч шахах, кабелийн цэгцлэгээ хийх шаардлагатай. Төгсгөвч хийгээгүйгээс холболт сулрах, халалт үүсэх магадлалтай байдаг. Ерөнхий оролтын самбаруудад нарийвчилсан үзлэг хийж, эрсдэлийн зэргээр ангилан шат дараажан сайжруулалт хийх шаардлагатай. Жижиг самбаруудад мөн цэгцлэгээ, цэвэрлэгээ хийх шаардлагатай. Зааланд байрлах самбар дээр халалт үүссэн, нарийвчилсан үзлэг хийж шалтгааныг тодруулах, тухайн самбарыг яаралттай шингэлэх шаардлагатай. Бусад самбаруудад мөн нарийвчилсан үзлэг хийж тооцооллын дагуу утас кабель таагдсан эсэх, автоматын гүйдлийн хамгаалалт тохирч байгаа эсэхийг шалгах шаардлагатай.

Үзлэг хийсэн

Монхорус Электрик ХХК:

..... / Э.Галбадрах, Ерөнхий инженер /
 / Д.Баярмагнай, Ахлах цахилгаанчин /
 / Б.Мөнхтуяа, Техникч /

MSM Group LLC:

..... /

SIKA BUILDING TRUST:

..... /

Тайлан гаргасан: / Б.Мөнхтуяа, Техникч /

Хянасан: / Э.Галбадрах, Ерөнхий инженер /

Хүтээн авсан: /

Хавсралт № 2.



"МСМ ГРУПП" ХХК

62, Чингисийн өргөн чөлөө, 3 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17070
УБД 2560526

Утас: 7718 1111

Цахим шуудан: information@msmco.net

Цахим хуудас: www.msmgroup.mn

2024.07.31 № 1400

танай _____-ны № _____

Мод тарих талбай авах тухай

Хан-Уул Дүүргий Засаг Даргын
Тамгын Газарт

МСМ Групп ХХК нь Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй Химийн бодисын агуулах төслийн хүрээнд 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулан ажиллаж байна. Тус төлөвлөгөөний орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө хэсэгт шинэс болон хайлаас мод нийт 20 ширхгийг тарихаар төлөвлөсөн хэдий ч төслийн талбайд мод тарих талбайн хүрэлцээ хангалтгүй байгаа болно.

Иймд бидний ажилд дэмжлэг үзүүлж, намар мод тарих талбай сонгож өгөхийг хүсье. Модны тарилтыг бид өөрсдөө хариуцан хийж гүйцэтгэх болно.

ХҮНДЭТГЭСЭН,

ҮЙЛ АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



НХМгагт Т-1

Саягийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5 өдрийн 347 тоот тушаалын хавсралт

№ НЭ20241022

2024-10-22

Нэхэмжлэгч:

Байгууллагын нэр: Хотон гэнэ?

Төлөгч:

Байгууллагын нэр: МСМ групп 2560526

Хаяг: Улаанбаатар хот Сонгино хайрхан дүүрг

Хаяг: Улаанбаатар хот Хан-Уул дүүрг

20-р хороо нэргийн хотхон 73-р 20 тоот

Утас, Факс: 99022355

3-р хороо

Банкны нэр: Хан банк

Утас, Факс:

Банкны дансны дугаар: 5657199636

Банкны нэр:

Банкны дансны дугаар:

№	Материал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ ₮	НӨАТ	НӨАТ-гүй дүн	Нийт дүн
1	Шинэс	ширхэг	10	80,000.00	0.00	0.00	800,000.00
2	Хайлаас	ширхэг	11	4,000.00	0.00	0.00	44,000.00
3	Модны дусал	ширхэг	10	25,000.00	0.00	0.00	250,000.00
4	Үхлээ бээжүүлэгч	ширхэг	10	16,000.00	0.00	0.00	160,000.00
5	Элс	шуудай	15	5,000.00	0.00	0.00	75,000.00
6	Үргэс	шуудай	6	7,000.00	0.00	0.00	42,000.00
7	Бууц	шуудай	3	9,000.00	0.00	0.00	27,000.00
8	Хар шороо	шуудай	10	9,000.00	0.00	0.00	90,000.00
9	Модний вигтахон	ширхэг	10	15,000.00	0.00	0.00	150,000.00
10	Ажлын хөлс		21	50,000.00	0.00	0.00	1,050,000.00
				Нийт дүн			2,688,000.00

Монгоний дүн үсгээр:

Хүснэгт сая дугаар эзэн нарын найман хөрөнгийн тусруу.

2,688,000.00

Нэхэмжлэгч:

Наранбаар

Нэхэмжлэл хүлээн авсан:

Нягтлан бодогч:

/



ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 01 сарын 12-ны өдөр

№ 24/003

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Нэг талаас Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, 6278558 тоот регистрийн дугаартай Хан-Уул дүүргийн ЭКО ХОТЫН ТЭЭВЭР ААТҮГ /цаашид Гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас 2580526 тоот регистрийн дугаартай, Хан - Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах ХУДАЛДАА/ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг /цаашид Захиалагч гэх/ нар доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээ нь 2024 оны 01 дугаар сарын 12-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.3 "Хог хаягдлын тухай" хуулийн хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орон сууц, гэр хорооллын айл өрх, ААН байгууллага болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.4 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 09-р сарын 26-ны өдрийн 12/45 дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ /нэмэгдсэн өртгийн албан татвар/-ыг тооцоогүй болно.

1.5 Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 04-р сарын 18-ны өдрийн А/29 тоот тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.

1.6 Хороо нь гэрээний дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх хуваарийн хэрэгжилтэд хяналт тавьж Захиалагч, Гүйцэтгэгч хоорондын уялдааг хангана.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

2.1 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, орон сууцны бункерийн хог хаягдлыг тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэх, ачилтын мэдээг тухай бүр хороонд мэдээлж ажиллах үүрэгтэй.

2.2 Гүйцэтгэгчийн тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар зохион байгуулалт хийн хогийг ачуулах арга хэмжээг авна.

4.1 Гэрээт хугацаанд сард РЕИС өдөр удаа иргэн, ААНБ-ийн бункерийн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.

4.2 Хог тээвэрлэлтийн төлбөр нь Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифын дагуу харилцан адилгүй байх бөгөөд тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу сард 150,000 төгрөг, улиралд 450,000 төгрөг, жилд 1,800,000 төгрөг байна.

4.3 Захиалагч нь itax.mta.mn цахим хаягаар орж төлбөрийн даалгавар үүсгэн нэхэмжлэхийн дугаараар хог хаягдлын хураамжаа хугацаанд нь бүрэн төлнө. 20-р хороо, Эко хотын тээвэр ААТҮГ-ыг сонгоно.

4.4 "Хог хаягдлын тухай" хууль, бусад эрх зүйн актыг үндэслэн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч үйлчилгээний үнийн тарифт өөрчлөлт оруулж болно.

4.5 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа гүйцэтгэгч тээвэрлэнэ.

4.6 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикийн дагуу төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.

4.7 Хог тээвэрлэлтийн төлбөрийг ААН, албан байгууллага, үйлчилгээний газрууд нь гэрээний 3.6-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 0.5%-ийн алданги төлнө.

Тав. Хамтран хүлээх хариуцлага

5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.

5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

5.3 Нийслэл, дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь 1 өдрөөр хойш шилжих асуудал гарч болно. Үүнийг тухайн ААН, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

Зургаа. Торгуулиас чөлөөлөгдөх нөхцөл

6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон.

6.2 Удирдах, дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд энэхүү гэрээний 5.2 дахь заалт хамаарахгүй.

Долоо. Бусад

7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

7.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

4.1 Гэрээт хугацаанд сард РЕИС өдөр удаа иргэн, ААНБ-ийн бункерийн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.

4.2 Хог тээвэрлэлтийн төлбөр нь Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифын дагуу харилцан адилгүй байх бөгөөд тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу сард 150,000 төгрөг, улиралд 450,000 төгрөг, жилд 1,800,000 төгрөг байна.

4.3 Захиалагч нь itax.mta.mn цахим хаягаар орж төлбөрийн даалгавар үүсгэн нэхэмжлэхийн дугаараар хог хаягдлын хураамжаа хугацаанд нь бүрэн төлнө. 20-р хороо, Эко хотын тээвэр ААТҮГ-ыг сонгоно.

4.4 "Хог хаягдлын тухай" хууль, бусад эрх зүйн актыг үндэслэн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч үйлчилгээний үнийн тарифт өөрчлөлт оруулж болно.

